



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
"ХӨГЖЛИЙН ТӨВ" ОНӨААТҮГ**

Баянзүрх дүүргийн Төр Захиргааны II байр,
Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороолол,
16 дугаар хороо, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13320
Утас: (976) 7707 4747
Цахим хуудас: www.dht.bzd.gov.mn

2024.12.05 № 295

танай _____-ны № _____-т

Үнийн санал хүсэх тухай

Тус Газар нь дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй босоо тогтолцоо бүхий байгууллагуудын нэгдсэн "Нэг цэг"-ийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа, албан хаагчдын харилцаа хандлага болон ажлын орчин нөхцөлийн талаарх "Хэрэглэгчийн үнэлгээ" судалгааг хавсралтад заасан удирдамжийн дагуу мэргэжлийн, хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна.

Иймд дээрх судалгааны ажлыг гүйцэтгэхээр сонирхож буй сургалт, судалгааны чиглэлийн эрх бүхий байгууллагууд судалгааг гүйцэтгэх үнийн санал, төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 10 цагаас өмнө ирүүлэхийг хүсье.

Судалгаа гүйцэтгэж дуусах хугацаа: 2025 оны 01 дүгээр сарын 10.

Хавсралт 3 хуудастай.



БАЯНЗҮРХ "ДҮҮРГИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Л.МӨНХЖАРГАЛ

2024 оны 04 дугаар сарын 05

ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ
"НЭГ ЦЭГ"-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ
ИРГЭДЭЭС АВАХ СУДАЛГААГ МЭРГЭЖЛИЙН
ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ТҮҮВЭР СУДАЛГААНЫ УДИРДАМЖ

2024 оны 04 дугаар сарын 05

Улаанбаатар хот

1. Нийтлэг үндэслэл

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ийн 9 дүгээр зүйлд заасны дагуу төрийн байгууллага жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээний судалгааг бүх аймаг, нийслэлийг хамруулан хийх ажлыг зохион байгуулна, шаардагдах зардлыг төсөвт тусган батлуулсан байна гэж заасан байдаг.

Хэрэглэгчийн үнэлгээг хийх хөндлөнгийн байгууллагыг судалгааны болон төрийн бус байгууллагын дундаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулна. Энэхүү удирдамжийг үндэслэл болгож төрийн байгууллагын хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг судалж, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох нөхцөл байдал үүсэж байгаа билээ

2. Судалгааны ажлын захиалагч: Баянзүрх "Дүүргийн хөгжлийн төв" ОНӨААТҮГ

3. Хэрэгжих хугацаа: 2024 оны 04 дүгээр улирал

4. Судалгааны сэдэв:

Баянзүрх дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны талаарх "Хэрэглэгчийн үнэлгээ" судалгаа

5. Судалгааны хэрэглээ

Түүвэр судалгааны үр дүнд үндэслэн тухайн төвлөрсөн байгууллагын ажилчдын ажлын байрны орчин нөхцөл, иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд албан хаагчдын зүгээс гаргаж буй харилцаа хандлага ёс зүйн асуудлыг тодруулан бодлого үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэхэд нэн чухал хэрэгсэл болгон ашиглана.

6. Судалгааны зорилго:

Баянзүрх дүүргийн хэмжээнд үйлчилгээ үзүүлж буй босоо удирдлагын тогтолцоо бүхий төрийн үйлчилгээний байгууллага буюу нэг цэгт төвлөрөн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, чанар хүртээмжийг судлах судалгааны ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

- ✓ Төрийн албан хаагчдын ажил үйлчилгээний ачааллыг үнэлэх,
- ✓ Нэг цэгийн үйлчилгээний ажилчдын ажлын байрны орчин нөхцөл
- ✓ Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн талаар тодруулах,
- ✓ Судалгааны үр дүнг үндэслэн төрийн ажил үйлчилгээг сайжруулах албан хаагчдын нийгмийн хамгааллын орчин нөхцөлийг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах

7. Хамрах хүрээ:

Баянзүрх дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй “Нэг цэг”-ийн үйлчилгээний төвд үйлчлүүлсэн иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний судалгааг авч гүйцэтгэнэ. Нийт 4 бүсийн 5 цэг хамрагдах

8. Судалгааны ажлыг гүйцэтгэх үе шатууд:

- ✓ Түүвэр судалгааг гүйцэтгэх болон эцсийн үр дүнг гаргах аргачлал (guideline)-ийг боловсруулах
- ✓ Судалгааны асуулгыг боловсруулах
- ✓ Түүвэр судалгаанаас цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийж нэгтгэн, эцсийн үр дүнг гаргах
- ✓ Судалгааны эцсийн үр дүнг тайлагнах, судалгааны тайланг бичих

9. Судалгааны аргачлал, аргазүй

Баянзүрх дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй “Нэг цэг” –ээс үйлчилгээ авсан иргэдээс түүвэрын аргаар судалгааг авах, цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийж, судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, холбогдох шинжилгээ, тайланг боловсруулах байдлаар гүйцэтгэнэ.

10. Судалгаанд тавигдах ерөнхий шаардлага:

Судалгааг энэхүү удирдамжид заасан зорилгын хүрээнд түүвэр судалгаагаар цуглуулсан мэдээлэлд тоон болон чанарын шинжилгээг хийж гүйцэтгэн нэгтгэн дүгнэнэ.

11. Судалгааны ерөнхий удирдлага:

Судалгааны захиалагч нь "Дүүргийн хөгжлийн төв" ОНӨААТҮГ байх бөгөөд судалгааны ажлын ерөнхий удирдлагыг хариуцна. Мөн судалгааны явцад хяналт тавих, гүйцэтгэгчид судалгааны ажилтай холбоотойгоор зохих шаардлагыг тавих эрхтэй байна.

Сонгон шалгаруулалт болон судалгааны ажлын хугацаа, үе шат

Хугацаа	Үе шат
2024.12.05	Судалгааны зар
2024.12.09	Судалгааны байгууллагаас мэдүүлэг хүлээж авах /эцсийн хугацаа/ судалгааг гүйцэтгэх төсөв болон төлөвлөгөөг гарган ирүүлэх
2024.12.10	Сонгон шалгаруулалт хийх, судалгааг гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулах
2024.12.18	Судалгааг гүйцэтгэгч судалгааны асуулга (guideline)-ийг боловсруулж, холбогдох мэдээллийг цуглуулж, мэдээлэлд боловсруулалт хийж, улмаар судалгааны тайлангийн эхний хувилбарыг бэлтгэн захиалагч талд хүлээлгэн өгөх
2024.12.20	Захиалагч тал судалгааны тайланд санал, зөвлөмж өгөх түгээх
2025.01.10	Судалгааг гүйцэтгэгч холбогдох санал, зөвлөмжийг тусган судалгааны тайлангийн эцсийн хувилбарыг захиалагч талд хүлээлгэн өгөх

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх үнийн дүн 19,800,000 (арван есөн сая найман зуун мянган) төгрөг

Судлаачид тавих шаардлага: Түүвэр судалгааны асуулгыг боловсруулах, мэдээллийн үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийх судлаачид нь мэргэжлийн өндөр түвшний бэлтгэл, ажлын туршлагатай, тухайн чиглэлээр бакалавр ба магистраас доошгүй зэрэгтэй, өмнө нь судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж байсан туршлагатай байна.